

## ДЭЛХИЙН ХАМГИЙН ЖИЖИГ УЛС -ВАТИКАН

*Л.Бэгзжав\**

Олон үеийн Ромын Пап нарыг залгамжилан гарч ирсэн, дэлхийн хамгийн жижигхэн хот улсын тэргүүн II Иоанн Павел<sup>1</sup> /Giovanni Paolo II/ нас сүүдэр 83 зэрэгцсэн ч дэлхийн хэмжээнд 30 гаруй жил идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй улс төр, шашны томоохон зүтгэлтэн билээ. Түүний гадаадад хийж буй 101 дэх удаагийн айлчлал нь Монгол Улсад тохиох гэж байна.

Тэртээ XIII зууны Их Монголын эзэнт гүрний үеэс Монголын их хаад Ромын Пап нартай харилцаж ирсэн түүхэн өнө эртний улбаа бий. Тиймээс ч Ватиканы алдарт музей, номын санд Монголын түүхийн холбогдолтой олон арван ном судар хадгалагдаж байдгийн зах зухаас нь манай эрдэмтэд танилцаж эхэлж байна. Монгол Улс Ватикантай 1992 оны 4-р сарын 24-нд дипломат харилцаа тогтоов. Дэлхийн 161 улс, бүс нутагтай албан ёсны дипломат харилцаатай Ватикан улс манай өмнөд хөрш БНХАУ-тай ийм харилцаагүй бөгөөд харин Тайваньтай дипломат харилцаатай юм. Энэ бүхнийг үл нуршин Ватиканы хот - улсын тухай товчхон өгүүлбэ.

\* \* \*

Stato della Citta del Vaticano буюу Ватиканы хот-улс нь Италийн нийслэл Ромын баруун хойд хэсэгт Монте-Ватикано толгод дээр бараг бүх талаараа чулуун хэрмээр хүрээлэгдсэн, 0,44 км<sup>2</sup> газар нутагтай, хилийн урт нь 2,6 км, хэсэгхэн газарт оршино.

1380 хүн амтайгаас 540 нь байнга оршин суугч, тэдний дийлэнхи нь италичууд ажээ<sup>2</sup>. Нийслэл нь Ватикан хот /Citta del Vaticano/, албан ёсны хэл нь итали, латин хэл. Төрийн далбаа, төрийн дуулал, төрийн сүлдтэй, улсын цэцэгтэй. Төрийн тэргүүн нь Ромын Пап II Иоанн Павел. Угийн нэр нь Kazol Wojtyla. Польш үндэстэн. 1978 оны 10-р сарын 16-нд Ромын Папаар сонгогдсон байна.

Ватикан бол эртний баялаг түүхтэй. МЭ 756 онд Ромын католик шашны тэргүүн II Стефанд тэр үеийн Франкогийн ван Италийн нутаг дэвсгэрээс булааж авсан Ром хотын орчим газрыг бэлэглэснээр Ромын Папын газар бий болжээ. Ромын Пап бол түүхэнд өрнөд Европын голлох ноёрхогч феодалын нэг байв. ХҮI зууны үеэс Европын шашны шинэтгэлийн хөдөлгөөнд түүний ноёрхох байр суурь удаа дараа

<sup>1</sup>Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор /Ph.D/ дэд профессор

хүчтэй өртөж байжээ. Газар нутгийнх нь хил хязгаар ч хожмын он жилүүдэд олонтаа өөрчлөгдөж улс нь хэдэнтэй сэргэн, мөхөж байв. 1870 онд Ромын Папын газар нутгийг Италийн вант улс нэгтгэн авч Ромын Пап Тибр голын эргийн Монте-Ватикано толгод дээрх Ватиканы ордонд бүгэн сууж, газар нутаг эзэмших эрхээ алджээ. Пап нэгдсэн Итали улсыг хүлээн зөвшөөрөлгүй, өөрийгөө “Ватиканы хоригдол”<sup>3</sup> хэмээн нэрлэж байв.

Ромын Пап, Италийн засгийн газрын зөрчил 1929 оны 2-р сарын 11-нд Италийн засгийн тэргүүн Муссолин, Ромын Пап XI Бих нарын гарын үсэг зурсан “Латераны гэрээ”-гээр эцэс болов. Хожим 2-р сарын 11-ний өдрийг Ватиканы улсын баярын өдөр болгон тэмдэглэх болжээ. Энэ хэлэлцээрээр Итали улс Ватиканыг шашны тэргүүнд захирагдсан, бүрэн эрхт улс гэж хүлээн зөвшөөрөв. Мөн Ватиканы хот улс байгуулж болно гэж заасаны дагуу 1929 оны 7-р сард Ватиканы хот улсыг албан ёсоор байгуулжээ.

Ватикан гэдэг нэрийн гарал нь Ватиканы өндөрлөгийн нэр юм. Есүс мэндэлэхээс өмнө, энэ өндөрлөгт мэрэгч төлөгч, зөн билэгч нар цуглаж хүний төөрөг тавиланг үздэг газар байсан гэж домоглон хэлэлцдэг ажээ. Ватиканы өндөрлөг нь латин хэлээр Mons Vaticanus бөгөөд үгийн гарвал нь Vaticania буюу мэрэгч төлөгч, далдыг харагчдын газар гэсэн утгатай юм байна<sup>4</sup>. Ватиканы өндөрлөгийг бас Holy see буюу Папын өргөө гэж нэрийддэг аж.

Ватиканы хот улс бол улс төр, шашин нь нэгдмэл улс юм. Төрийн тэргүүн Пап бол хууль тогтоох, шүүх засаглал, засаг захиргааны хамгийн дээд эрхийг барьдаг бөгөөд “Христосын амьд бие төлөөлөгч” гэж өөрийгөө өргөмжилдөг байна. Пап бол Кардинал<sup>5</sup> нарын 2/3-аас дээш хувийн саналаар сонгогдож, насан туршдаа үүрэгт ажлаа гүйцэтгэнэ. Кардиналын бүлэг бол Папын зөвлөлдөх байгууллага ба одоо 130 хүнтэй. Үүнээс 80-иас доош настай Папад сонгогдох эрхтэй 105 хүн байгаа.

1988 оны 6-р сард Пап “ордны шинэтгэл” хийж засгийн газрынхаа зарим байгууллагад зохицуулалт хийжээ. Одоогийн Засгийн газрын нь гол байгууллага нь Улсын явдлын нарийн бичгийн дарга нарын газар бөгөөд Папын шууд удирдлагад байж, Папад туслах үүрэгтэй дотоод байдал, гадаад харилцааг эрхэлнэ. Ерөнхий сайдын үүргийг Папын томилсон төрийн нарын бичгийн дарга гүйцэтгэх ба эрх мэдэл нь Папын дараа орох аж. Гадаад харилцааны нарийн бичгийн

дарга буюу Гадаад хэргийн сайдтай. Шашны талын 9 яамтай. Ватиканы аюулгүй байдлыг Швейцарийн 100 гаруй шадар цэрэг гүйцэтгэдэг<sup>6</sup>.

Ватикан нь хэдийгээр аж үйлдвэр, байгалийн баялаг ерөөс байхгүй ч санхүүгийн гол орлого нь аялал жуулчлал, шуудангийн марк, үл хөдлөх хөрөнгийн түрээс, банкны ашиг, сүсэгтэн олны өргөл барьц, Папад бэлэглэж, хандивласан мөнгө зэрэг болно. Хэдийгээр хүн ам нь хэт цөөхөн боловч гадаадад хэдэн тэрбум долларын хөрөнгө оруулалттай, алт валютын асар их нөөцтэй тул эртнээс “алтан гулдмайт шашны орон” гэж хол ойрдоо алдаршжээ. Ялангуяа Хойт Америк, Европын олон улсад хэдэн зуун тэрбум ам.долларын хөрөнгөтэй, Италийн эдийн засгийн бүх салбарт нэвтэрсэн, банк зээл, орон сууц, газрын үл хөдлөх хөрөнгийн ихэнх нь Ватиканы мэдэлд бөгөөд зөвхөн газрын үл хөдлөх хөрөнгө гэхэд өөрийнх нь газар нутгаас 1 сая гаруй дахин том буюу 460 мянган га болно. Алт, гадаад валютын нөөц нь 1 тэрбум гаруй америк доллар.

Ватикан нь Итали, Франц, Испани, Бельги, АНУ, Канад, Бразил, Чили, Этиоф, Филиппин, Япон зэрэг оронд их сургууль буюу шашны дээд сургууль байгуулсанаас гадна дэлхийн олон орон, бүс нутагт сургууль, эмнэлэг, соёлын байгууллага олноор байгуулжээ.

1475 онд байгуулагдсан Ватиканы номын санд дэлхийд нэртэй, нэн эртний ховор гар бичмэл, ном судар хадгалагдаж байна. Зөвхөн гар бичмэл гэхэд 65 мянга, байгаагаас гадна 900 мянган боть ном байгаа аж. Уг номын сангаас Монгол, Ватиканы харилцааны холбогдол бүхий 30 орчим захидал олдоод байгаа ба 1700 онд барлагдсан Хятад, Монгол толь бичиг ч байгааг академич Д.Цэрэнсодном гуай мэдээлж байв<sup>7</sup>.

Мөн дэлхийн хамгийн эртний музей болох Ватиканы музей дэлхийд хосгүй. Эндэхийн тоо томшгүй зураг хөрөг, урлагийн үнэт бүтээлүүдийг агуу их Микеланжело, Рафзаль, Ж.Дела Порта нарын суутнууд бүтээснийг үзэх гэсэн газар газрын жуулчны цуваа огт тасардаггүй газар юм. 1984 онд ЮНЕСКО Ватикан хотыг дэлхийн соёлын өвийн хамгаалалтанд авсан нь зүй ёсных билээ.

Нийгмийн номлол нь хувийн өмчийг хамгаалах, ангийн эрх тэгш бус байдлыг арилгах явдал байдаг Ватикан олон жилийн турш коммунист үзэл суртлын эсрэг суртал ухуулгын төв байсан бөгөөд өдөрт 35 хэл дээр 24 цагийн нэвтрүүлэг тасралтгүй хийдэг. Өдөр тутмын, цорын ганц албан ёсны “Оссерваторе романо” сонин 1861 онд анх

бий болсон ба итали, франц, португали, испани, герман, польш хэлээр долоо хоног тутмын хавсралт гаргадаг.

Ватиканы хот улс олон үзүүлэлтээрээ дэлхийн хамгийн бага орон гэгддэг боловч дэлхийн бодлогод, ялангуяа католик шашинтай орнуудад нөлөө бүхий “том” орон юм.

Жич: “Монгол нэвтэрхий толь”-д Ватиканы тухай мадагтай мэдээлэл өгчээ<sup>8</sup>. Эндээс Ватиканы хот-улсын талаар ямар нэг төсөөлөл авахад бэрхтэй юм.

### ЭШЛЭЛ ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Манай хэвлэлүүдэд Ромын Хамба лам- гэж бичиж байгаа нь угтаа ташаа зүйл юм. Буддын шашны сүм хийдийн тэргүүнийг хамба лам, христос шашныхыг епископ, үнэн алдартны шашныхыг епархии, армян, гүржийн үнэн алдартны шашныхыг католикос гэх мэт нэрлэдэг билээ. Ромын /Ватикан/ католик сүм хийдийн тэргүүнийг Папа гэнэ. Энэ нь грек хэлний эцэг гэдэг үгнээс үүдэлтэй. Ромын хамба лам гэх нь угтаа өөр өөр шашны ойлголт нэр томъёог буддын шашны нэрээр илэрхийлсэн хэрэг бөгөөд их эрдэмтэн Б.Ринчен гуай “Парисын дарь эхийн сүм” романы орчуулгыг шүүмжилж Францад “дарь эх” гэж байдаггүй, харин өөрийнх нь шашны “эх дагина” гэсэн ойлголт байдаг гэж хэлж байсантай нэгэн адил утгатай юм.
2. Geguo zaikuan /ou zhoul/. “Дэлхийн улсуудын байдал-Европ”, Бээжин. “Дэлхийн мэдлэг” хэвлэлийн газар. 2002 оны 7-р сар, 111-р тал.
3. Большая Советская энциклопедия. Т.4. М., 1971, стр 982-989.
4. Жан Жунсянь. Shijie geguo guomin jijin. Бээжин. 1987. 105-р тал.
5. Кардинал -латин хэлний гол, ерөнхий гэсэн утгатай үг. Католик шашинд Папын дараах хэргэм зэрэгтний цол, улаан хувцаст епископ гэх нь ч бий.
6. Shijie zhishi huaбао. /Дэлхийн мэдлэг зурагт сэтгүүл/ 1997 он. №8. 2-р тал.
7. Д.Цэрэнсодном: Ватиканы номын санд хүний гар хүрээгүй. /ярилцлага/. “Үнэн” сонин. 2002.01.03. №01.
8. Монголын нэвтэрхий толь. I боть. УБ. 2000. 213-р тал